

## **1. Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах**

- 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-д хүргүүлэх

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авилгатай тэмцэх газраас хүргүүлсэн аргачлалын дагуу тус газраас санал аван нийт 16 ажил, 29 арга хэмжээтэйгээр батлуулж, хүргүүлсэн болно. Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтсүүд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажилласан.

- Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан, хугацаа зэргийг харгалзан хэрэгжүүлэн ажилласан.

- Тайлан, нотлох баримтыг хүргүүлэх

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ..хуудас, нотлох баримт ... хуудсын хамт тус газрын даргын 2014 оны .... дугаар сар ...-ны өдрийн ...дугаар албан бичгээр Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн.

## **2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах**

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар ажилтнуудад танилцуулга хийх г.м

2014 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн “Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн дарга, архив бичиг хэргийн ажилтнуудад зориулсан сургалт” хөтөлбөрт цаг оруулж аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтсийн дарга, архив бичиг хэргийн мэргэжилтэн нийт 93 мэдүүлэг гаргагч нарт “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан хичээл”-ийг зааж, хуулийн хугацааг сануулсан.

WAC3

Мөн 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын их хурлаас баталсан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад баталсан нэмэлт, өөрчлөлтөөр: байгууллагын Ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч нар хуулийн үйлчлэлд хамаарч ХАСХОМ гаргах, мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол 30 хоногийн дотор мэдүүлж байх зэрэг нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх талаар Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2014 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 2/160 тоот албан бичгээр харьяа аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэс, Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвд хүргүүлж нийт албан хаагчдад сурталчлан мэдээлж, мөрдөж ажиллахыг үүрэг болгосон.

ХҮҮЕГ-ын нийт албан хаагчдад 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг” сургалт орсон.

2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Нийгмийн халамжийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-д Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн дарга наарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль холбогдох дүрэм, журмуудаас цаашид анхаарвал зохих арга хэмжээ, хэлтсийг нэр цохон тэмдэглэж хууль, журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сануулан ажилласан.

Налайх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль холбогдох бусад дүрэм, журам, зааврын хүрээнд “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сэдэвт сургалтыг дараах дэд

сэдвүүдтэйгээр зохион байгуулан ажиллалаа. Сургалтанд нийт 23 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Сургалтын сэдэв:

1. ХАСХОМэдүүлэг гаргагчийн тухай
2. ХАСХОМ хэнд гарган өгөх тухай
3. ХАСХОМэдүүлэг гаргагчийн үүрэг
4. ХАСХОМэдүүлэг хэрхэн бөглөх тухай

Мөн 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан, комисsar н.Балдандоржыг урьж “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сэдэвт хичээлийг нийт ажилтан, албан хаагчдад орсон.

3. Салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах, жагсаалтыг АТГ-т хүргүүлэх /хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх дүрэм, журмыг нэрээр нь байршуулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх/

Halamj.gov.mn-Хууль эрх зүй-нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан тушаал-Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмууд 2013, 2014 гэсэн дарааллын дагуу байршуулсан. Жагсаалтыг хавсралтаар хүргүүлсэн.

4. НХҮЕГ-аас гадагш чиглэсэн хяналт шалгалт /хаана, ямар хяналт шалгалт хэрэгжүүлэх тухай нэрээр дурдаж бичих/

- Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байдал /төлөвлөгөө/

Halamj.gov.mn-Ил тод байдал-Хяналт шалгалт-Хяналт, шалгалтын төлөвлөгөө 2014 гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- Хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээний нээлттэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ

Halamj.gov.mn-Зөвлөмж-Зөвлөмж гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний мөрөөр авсан арга хэмжээний үр дүн

Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад хийсэн хяналт, шинжилгээ, дотоод аудитын зөвлөмж, аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүдэд “Үр дүнгийн гэрээний хэрэгжилт”-ын талаар зөвлөмж өгч ажиллаж байна.

#### **5. Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг веб сайтад байршуулах**

- НХҮЕГ-ны 2014 оны төсөв

Halamj.gov.mn-Санхүү-Төсөв-2014 оны төсөв гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- 2013 оны төсвийн гүйцэтгэл

Halamj.gov.mn-Санхүү-Санхүүгийн тайлан-Санхүүгийн тайлан гэсэн дарааллын дагуу байршуулсан. (Төсвийн гүйцэтгэл нь санхүүгийн тайланда тусдаг.)

- 2015 оны төсвийн төсөл

Halamj.gov.mn-Санхүү-Төсөв-2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- 2013 оны санхүүгийн тайлан

Halamj.gov.mn-Санхүү-Санхүүгийн тайлан-Санхүүгийн тайлан гэсэн дарааллын дагуу байршуулсан. Харьяа газар, хэлтсүүд өөрийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбартaa байршуулан ажиллаж байна.

- 2013 оны санхүүгийн тайланда хийсэн аудитын дүгнэлт

Halamj.gov.mn-Санхүү-Аудитын дүгнэлт-Аудитын дүгнэлт 2013 /1-3-р хэсэг/ гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- 2014 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

Төсөвт өөрчлөлт ороогүй болно.

- Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаарх 2013 оны мэдээлэл /татварын, татварын бус/

Тус байгууллага нь зөвхөн улсын төсвөөс бүрддэг, улсын төсвийг бүрдүүлдэггүй болно.

- Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний талаарх мэдээлэл

Байхгүй.

- 2014 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг вебсайтад байршуулах

2014 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг [Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Ил тод байдал-Хүний нөөц-Ахмад настан гэсэн дарааллын дагуу байршуулсан.

- 2014 онд гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр жагсаалтыг гаргаж АТГ-д ирүүлэх

Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр нь ХАХНХЯамны шууд удирдлаган доор явагдаж, шууд санхүүждэг болно. Иймд тус мэдээллийг ХАХНХЯамны холбогдох тайлангаас нягтлана уу.

- Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг вебсайтад байршуулах

Гадаадын зээл, тусlamжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр нь ХАХНХЯамны шууд удирдлаган доор явагдаж, шууд санхүүждэг болно. Иймд тус мэдээллийг ХАХНХЯамны холбогдох тайлангаас нягтлана уу.

6. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжийг хангах

- Байгууллагын вебсайтад байршуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын мэдээлэлд баяжилт хийх

Тус газар нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.2-т заасан иргэн, аж ахуй нэгж байгууллагыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж гэрчилгээ олгоно” гэсний дагуу бүртгэлийг [Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Халамжийн үйлчилгээ-Асрамжийн төвүүд гэсэн дарааллын дагуу байршуулсан.

Тус газраас олгож буй зөвшөөрлийн жагсаалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг [Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Халамжийн үйлчилгээ-Зөвшөөрөл хэсэгт байршуулсан. Мөн холбогдох журмыг [Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Хууль тогтоомж хэсэгт байршуулсан.

[Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Халамжийн үйлчилгээ-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ-Хамтрагч байгууллагууд-Сэргээн засах өдрийн үйлчилгээ үзүүлэх байгууллагууд, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ олгогдсон байгууллагууд, 2014 онд нэмэгдсэн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх гэрчилгээ олгогдсон байгууллагууд гэсэн дарааллын дагуу байршуулсан.

[Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Халамжийн үйлчилгээ-Ахмад настны [НХҮ-Ахмадын](#) зориулалттай амралт сувилал гэсэн дарааллын дагуу байршуулсан.

## **7. Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах**

- Сул орон тооны зарыг вебсайтад байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах

Дорноговь аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга, Дорнод аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Захиргаа, хяналтын албаны дарга нарын сонгон шалгаруулалтын хүсэлтийг ХАХНХЯамны ТАСЗ-д хүргүүлж тус ТАСЗ зарыг “Зуун мэдээ” сонинд 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дугаар, [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn)гэсэн цахим хуудсаны “Төрийн жинхэнэ албаны

мэргэшлийн шалгалт→Мэргэшлийн шалгалтын зар, мэдээлэл" гэсэн хэсэгт нийтлэсэн.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга, Баянзүрх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Захиргаа, хяналтын албаны дарга сонгон шалгаруулалтын ХАХНХЯамны ТАСЗ-д хүргүүлж тус ТАСЗ зарыг "Зуун мэдээ" сонинд 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн дугаар, [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) гэсэн цахим хуудсаны "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт→Мэргэшлийн шалгалтын зар, мэдээлэл" гэсэн хэсэгт нийтлэсэн.

Говьсүмбэр аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга, тус аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Нийгмийн халамж, хүн амын хөгжлийн асуудал хариуцсан албаны дарга сонгон шалгаруулалтын ХАХНХЯамны ТАСЗ-д хүргүүлж тус ТАСЗ зарыг "Зуун мэдээ" сонинд 2014 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дугаар, [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) гэсэн цахим хуудсаны "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт→Мэргэшлийн шалгалтын зар, мэдээлэл" гэсэн хэсэгт нийтлэсэн.

- Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж АТГ-д ирүүлэх

Тайлант хугацаанд нийт 19 албан хаагч (давхардсан тоогоор) томилогдоноыг хавсралтаар хүргүүлсэн.

- Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагыг хангах

"Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын Хүний нөөцийн үйл ажиллагааны стратегийг үнэлэх журам"-ыг [Halamj.gov.mn](http://Halamj.gov.mn)-Ил тод байдал-Хүний нөөц хэсэгт байршуулсан.

Halamj.gov.mn-Бидний тухай-Ёс зүйн дүрэм-Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм гэсэн дарааллын дагуу байршуулсан.

Halamj.gov.mn-Зөвлөмж-Зөвлөмж гэсэн дарааллын дагуу байршуулсан.

Албан хаагчдын CV анкетийг (нотлох баримтанд хавсаргасан), сэтгэл ханамжийн судалгаа (нотлох баримтанд хавсаргасан) шинэчлэсэн.

Тус газрын Ёс зүйн хороог Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу нийт ажилтан, албан хаагчдаас саналаар шинэчлэн НХҮЕГ-ын даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 41 дугаар тушаалаар байгуулан төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлд 2014 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 2/279 дугаар албан бичгээр “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Төрийн байгууллагын соёл ёс зүйн сэдэвт сургалт”-ыг зохион байгуулахыг хүссэн. Уг хүсэлтийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны институттээс Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Төрийн байгууллагын соёл ёс зүйн сэдэвт сургалт”-ыг 2014 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Б.Нямсүрэн мэргэжилтэнг урьж сургалт зохион байгуулсан.

Тус газрын Ёс зүйн хороо 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Налайх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбат, Нийгмийн халамж, хүн амын хөгжлийн албаны дарга Г.Ариунбулаг нартай холбоотой гарсан ёс зүйн асуудлаар хэлэлцэж, Налайх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга П.Чинбат нь ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж дүгнэлт гаргасан. Дээрх дүгнэлтийг үндэслэж Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн 82 дугаар тушаалаар Налайх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга

П.Чинбатад “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулж, цаашид төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахин ажиллахыг үүрэг болгон ажилласан.

2014 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 2/280 дугаар аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар хэлтэст “Чиглэл өгөх тухай” албан бичгээр “Ёс зүйн хороо” байгуулж ажиллахыг үүрэг болгосон.

Halamj.gov.mn-д мэдээлэл хүлээн авах тухай боломжийг бүрдүүлсэн.

**8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах**

- Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, веб сайтад байршуулах

2014 оны төлөвлөгөөг 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулж Halamj.gov.mn-Ил тод байдал-Санхүү-Тендерийн мэдээ-Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн дарааллын дагуу байршуулсан. Учир нь тус газрын 2014 оны төсөвт барилга угсралтыг гүйцэтгэх, техник хэрэгсэл нийлүүлэх төсөв суугдаагүй бөгөөд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны өдрийн А/36 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг шилжүүлсний үндсэн дээр Сэлэнгэ, Завхан, Баянхонгор, Дархан-Уул аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн барилга угсралтыг гүйцэтгэх, техник хэрэгсэл нийлүүлэх тендерийг зохион байгуулсан.

Ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах зарыг Өдрийн сонины 2014 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн №009 дугаар, e-procurement.mn сайт дээр тус тус нийтлэсэн.

Сэлэнгэ, Завхан, Баянхонгор, Дархан-Уул аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Батсүмбэр дэх Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн барилга угсралтыг гүйцэтгэх, техник хэрэгсэл нийлүүлэх зарыг Өдрийн сонины 2014 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 25-р нүүр, 2014 оны 03 дугаар

сарын 17-ны өдрийн 4-р нүүр, 2014 оны 04 дүгээр сарын 01-ниы өдрийн 3-р нүүр, 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 10-р нүүр, 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 10-р нүүр, e-procurement.mn, halamj.gov.mn сайт дээр тус тус нийтлэсэн.

Хүнсний цаасан эрхийн бичгийг хэвлэх байгууллагыг сонгон шалгаруулах зарыг холбогдох хуульд заасны дагуу харьцуулалтын аргаар "Жи би эс жи би" ХХК, "Үндэсний үнэт цаас" ХХК, "Интерпресс" ХХК-д тус тус албан бичгээр урилга хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн дэвтэр, маягт, хувийн хэрэг, ахмадын амрах эрхийн бичиг, тараах материал хэвлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг холбогдох хуульд заасны дагуу харьцуулалтын "Жи би эс жи би" ХХК, "Дебетсет" ХХК, "Шинэ эрин од" ХХК, "Тэрх чандмань" ХХК-д тус тус албан бичгээр урилга хүргүүлсэн.

- Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, веб сайтад байршуулах

Хуулийн хугацаа болоогүй санал авч боловсруулж байна.

- Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл

Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг Halamj.gov.mn-Ил тод байдал-Санхүү-Тендерийн дүн гэсэн дарааллын дагуу байршуулсан.

#### **9. Төрийн албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах, вебсайтад байгаа мэдээлэлд зохих өөрчлөлт оруулах**

Тус газрын 55 төрийн албан хаагч бүрийн овог нэр, албан тушаал, холбоо барих утас, өрөөний дугаар, албан и-мейл хаягыг шинэчлэн halamj.gov.mn-Ил тод байдал-Хүний нөөц-Албан хаагчдын мэдээлэл гэсэн дарааллын дагуу байршуулсан.

Мөн тус газрын нийт ажил хариуцсан 47 албан хаагчийн овог нэр, албан тушаал, ажил үүрэг, холбоо барих утас, и-мейлийг halamj.gov.mn-Ил тод

байдал-Хүний нөөц-Албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг гэсэн дарааллын дагуу байршуулсан.

**10. Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөний дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах/сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн зарим үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх /ямар арга хэмжээг хамtran хэрэгжүүлэх талаар тодорхой тусгах/**

Мерси Кор Монгол Олон Улсын байгууллагатай 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр /Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Завхан/ 15 аймагт “Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан” боловсруулах талаар хамtran ажиллах санамж бичгийг байгуулсан. Дээрх санамж бичгийн хүрээнд 15 аймаг дахь Мерси Кор Монгол Олон Улсын байгууллагын салбар төвүүдтэй хамtran Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын харьяа Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүдийн авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулах, батлах үйл явцад орон нутгийн иргэдийн дуу хоолой болон оролцоог бий болгон Иргэний танхimuудаар дамжуулан холбогдох хэлэлцүүлгүүдийг хамtran зохион байгуулж, сайн засаглалыг бэхжүүлэх, авлигаас анgid байх хандлагыг нийгэмд бий болгоход орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор Мерси кор байгууллага нь дэд тэтгэлгийг олгох, сургалт, туршлага солилцох зэрэг ажлуудыг зохион байгуулж, орон нутгийн ИНБ-н чадавхийг нэмэгдүүлж төслийн зорилтот аймгуудын Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсүүдийг иргэдэд хүрсэн авлигын эсрэг стратеги төлөвлөгөөтэй болоход дэмжлэг үзүүлсэн. Санамж бичгийн дагуу 2014 оны 9 дүгээр сард хамтын ажиллагааг дүгнэх байсан боловч хойшлогдож дүгнэлтийг хэлэлцэж байна.

Ил тод байдал сан ТББ-н ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын ил тод байдлын картыг бөглөж 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдөр 2/938 тоот албан бичгээр хүргүүлсэн.

**11.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргах**

Тус газрын дарга 2014 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад нийцүүлэн “Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын давхар ажил эрхэлж болох жагсаалт”-ыг баталсан.

**12.Давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах**

2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад “Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын давхар ажил эрхэлж болох жагсаалт”-ыг танилцуулж “Давхар ажил эрхлэлтийн талаар судалгаа” авсан. Судалгаанд нийт 11 албан хаагч байгаагаас 6 албан хаагч нь хуульд хориглосон ямар нэгэн давхар ажлыг эрхлээгүй, 5 албан хаагч нь сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын гишүүн бөгөөд энэ талаар Авлигатай тэмцэх газарт 2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1/1095 дугаар албан бичгээр судалгааг хүргүүлсэн болно.

**13.Удирдлагаас гаргасан тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг цахим хуудсанд байршуулах**

Холбогдох хууль, тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад удирдлагаас 2014 онд гаргасан тушаалыг Halamj.gov.mn-Хууль эрх зүй-Тушаал, шийдвэрүүд-Даргын тушаал 2014 гэсэн дарааллын дагуу байршуулсан.

Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомжийг Halamj.gov.mn-Хууль эрх зүй-Хууль тогтоомж хэсэгт байршуулсан.

Үйлчлүүлэгчээс авч буй ямар нэгэн төлбөр хураамж байхгүй болно.

#### **14. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах**

- Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах /уг арга хэмжээнд олон нийтийг татан оролцуулах, тодорхой судалгаа шинжилгээний үндсэн дээр тулгуурлах/
- Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх

Тус газрын даргын 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/1227 дугаар “Албан даалгавар хүргүүлэх тухай” албан бичгээр Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтны жагсаалт гаргаж, тэдгээрийн ажлын үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон. Уг албан даалгаврын дагуу Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтны жагсаалтыг тус газар болон харьяа аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэс бүр өөрийн өөрийн байдлаар гаргаж, тэдгээрийн ажлын үйл ажиллагааг хянах нөхцөл боломжийг тус тусдаа бүрдүүлсэн байна. Дээрх жагсаалт, хянах үйл ажиллагаа зэргийг нэгтгэж ерөнхий нэг ойлголттой болох амьдралд хэр бодитой болох одоогийн үйл ажиллагаа явуулж буй хуулийн хүрээнд хянах нөхцөл боломж бий эсэх эсхүл авлигагүй салбар гэх талаар саналыг авч “Удирдлагын зөвлөл”-д танилцуулахаар цогцоор нь судалгаа хийж байна.

- Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах

Halamj.gov.mn-Зөвлөмж-Чиглэл гэсэн дарааллын дагуу тус газрын даргын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1/15 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг байршуулсан.

Тус газрын тэргүүн дэд даргын 2014 оны 2 дугаар сарын 2/160 дугаар албан бичгээр аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэст “Хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх, судалгаа авах тухай”, даргын 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1140 дугаар “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай”, 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/1227 дугаар “Албан

даалгавар хүргүүлэх тухай” албан бичгийг аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж ажилласан.

2014 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн 780 дугаар албан бичгээр “Сумын нийгмийн халамж, үйлчилгээний мэргэжилтний тухай” зөвлөмж ирсэн. Зөвлөмжийн дагуу тус газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1/933 дугаар албан бичгээр “Хамтран ажиллах тухай” хүсэлтийг 21 аймгийн Засаг дарга нарт, тэргүүн дэд даргын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 2/934 дугаар албан бичгээр “Ажил сайжруулах тухай” албан даалгаврыг 21 аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга нарт хүргүүлсэн. Нийт 315 сумын Засаг дарга, сум хариуцсан мэргэжилтэн нар Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх дүгнэх журам”-ын 1.7 дахь заалтын дагуу үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс нь Сум хариуцсан нийгмийн халамж, үйлчилгээний мэргэжилтэнг өдөр тутмын нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих, хөдөлмөрийн харилцааг зохицуулж ажиллах талаар хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, цагийн бүртгэл, өдөр тутмын ажлын явц, хагас болон бүтэн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг сумын Засаг даргаас авч нэгтгэн дүгнэж байна гэсэн хариуг тус газрын даргын 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1139 дугаар албан бичгээр хариуг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

#### **15. Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээлэх**

Тайлант онд авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### **16. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх**

- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмж
1. 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 03/9175 дугаар “Сургагч багш бэлтгэх тухай”

Тус сургалтанд эрх бүхий албан тушаалтан Б.Дөлгөөнийг сургалтанд хамруулж “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” сургагч багшийн сертификат гардаж авсан.

2. 2013 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 01/10134 дугаар “2014 оны мэдүүлэг бүрдүүлэлтийн үйл ажиллагааны тухай”

Тус газрын даргын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 1/162 дугаар алба бичгээр ХАСХОМ нэрс хүргүүлсэн.

3. 2014 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/1259 дугаар “Хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх тухай”

Тус газрын тэргүүн дэд даргын 2014 оны 2 дугаар сарын 2/160 дугаар албан бичгээр аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэст “Хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх, судалгаа авах тухай” хүргүүлсэн.

4. 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 03/1294 дугаар “2013 онд үйлчлүүлсэн иргэд, аж ахуй нэгж байгууллагын тоо (давхардсан тоогоор)”

Тус газрын тэргүүн дэд даргын 2014 оны 2 дугаар сарын 2/160 дугаар албан бичгээр аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэст “Хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх, судалгаа авах тухай” хүргүүлэх судалгааг авч нэгтгэн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 2/192 дугаар албан бичгээр судалгааг хүргүүлсэн.

5. 2013 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 1/8006 дугаар “Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны бичмэл тайлан ирүүлэх тухай”

Тус газрын тэргүүн дэд даргын 2014 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 2/202 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

6. 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдрий 03/3465 дугаар “Сургалт зохион байгуулах тухай”

Сургалтанд хамрагдсан.

7. 2014 оны 04 дүгээр сарын 22-ны 03/3236 дугаар

2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 1/1582 дугаар албан бичгээр Дархан-Уул аймгийн НХҮХ-ийн дарга Ж.Ганболдын ХАМХОМ-ыг хүргүүлэв.

8. 2014 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 01/4211 дугаар

2014 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 2/812 дугаар албан бичгээр судалгааг хүргүүлэв.

9. 2014 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 03/6138 дугаар

2014 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1/1095 дугаар албан бичгээр судалгааг хүргүүлсэн болно.

10. 2014 оны 08 дугаар сарын 22-ны 03/7007 дугаар “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай”

2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 1/1193 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.

11. 2014 оны 10 дугаар сарын 13-ны 05/8451 дугаар “Гомдол шалгуулах тухай”

2014 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 9/1267 дугаар албан бичгээр хариу өгсөн.

Боловсруулсан: Эрх бүхий албан тушаалтан

Б.Дөлгөөн

Хянасан: Тамгын газрын дарга

Д.Баасансүрэн

